



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

Хөрөнгө шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1,3, 30.1.16, 30.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1, 31.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газарт бүртгэлтэй Нийслэлийн Аврах анги-105-д ашиглагддаг 84-39 УБЦ улсын дугаартай УАЗ-469 маркийн автомашиныг Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 74 дүгээр анги шинээр байгуулагдсантай холбогдуулан техник, хүч хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс түр шилжүүлэн үүрэг гүйцэтгүүлсүгэй.

2. Техникийн комиссын нотломж үйлдэн хөрөнгийг түр шилжилт хөдөлгөөн хийхийг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т даалгасугай.

3. Техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хангуулан томилгоот хуваарьт оруулахыг Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс (дэд хурандаа Т.Мөнхдорж)-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЧУЛТЭМСҮРЭН

